

**“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-НЫ  
ӨНГӨ ЗҮС ЗААСАН “ГУА” ХЭМЭЭХ ҮГИЙН УЧИР**

Н. Балжинням \*

“Монголын нууц товчоон”-ы нэгдүгээр бөлөгийн нэгдүгээр зүйлд “Чингис хааны язгуур, дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртө-Чино, гэргий *Гуа-Маралын* хамт тэнгис далайг гэтэлж ирээд, Онон мөрний эх Бурхан Халдун ууланд нутаглаж, Батцагаан гэдэг нэгэн хөвгүүнийг төрүүлжээ” гэдэг өгүүлбэр бий/Академич Ц.Дамдинсүрэнгийн орчуулга/. Энэ өгүүлбэрийн *Марал* хэмээх үгийн тодотгол *Гуа* гэдэг үгийг Монголын Нууц Товчоо-г судалсан зарим эрдэмтэд өөр өөрөөр ойлгож, бичиж, орчуулж, галиглаж зохих тайлбарыг дагалдуулан хийж ирсэн байна. Миний бие эрдэмтэн-судлаачидын эдгээр санал, дүгнэлтүүдийг зэрэгцүүлэн үзэж чухам аль нь оновчтой байж болохыг тодруулахыг хичээсэн юм. Энд харьцуулан үзсэн **Монголын нууц товчоон** болон түүнд холбогдох монгол хэл шинжлэлийн ном зохиолыг хэвдэгдэн гарсан онуудыг дарааллуулан авч үзвэл:

1. **Цэнд** гүний Нууц товчооны гар бичмэл орчуулгад [qou-a maral, mongoljin gou-a... ] гээд ямар нэг тайлбар, дагалдуулал хийгээгүй байна.

2. **А.М.Позднеев** Нууц товчооны бичвэрийн галиг хэмээх чулуун барын гар бичмэлдээ [xo`ай марал] (1-р тал) гэж галиглаад, түүнийгээ *хадмал орчуулгад нёстрый лань* (мөн талд) гээд монгол бичгээр сэргээхдээ [ᠬᠣᠠᠢ ᠮᠠᠷᠠᠯ - qow-a maral] (61-р тал) гэжээ. *Монголжин гоа* (2-р тал), *Борохчин гоа* (мөн тал), *Алан гоа* (3-р тал) гээд *гоа* гэдгээ монгол бичгээр ᠭᠣᠠ - *юи-а* (62-р тал) гэжээ. Тэрээр *Хоай гэдэг нэрийг* ᠬᠣᠠᠢ - *юи-а* хэмээн бичих бөгөөд *уншихдаа Хо гэх ба энэ нь прекрасный (гоё сайхан) (106-р тал) гэсэн үг юм. Цааш нь Хо`ай* (ᠬᠣᠠᠢ - qowa) хэмээх энэ үгийг Алтан товчийн гар бичмэлээс харсан тухайгаа тус тус тэмдэглэжээ (107-р тал).

3. **А.С.Козин** Нууц товчоог латин галигт буулгахдаа *Qo`ai - Maral* (7-р тал), *Boroqcin-qoa, Alan-qoa* (80-р тал) гээд орос орчуулгад *Гоа-Марал, Монголчжин-гоа, Борогчин-гоа, Алан-Гоа...* (мөн талд) гэжээ. Тэрээр *qo`ai* гэдэг нь *прекрасный* гэсэн үг гэж тайлбарлав.

4. **К.Ширатори** Нууц товчоо-г латин галигт буулгахдаа [*γoγai maral, mongoljin γoγa, Alun γoγa...*] гэв. Дагалдах тайлбар хийгээгүй байна.

\* МУИС-ийн МХСС-ийн Гадаад хэлний тэнхим

5. **Ц.Дамдинсүрэн** Нууц товчоо-г хуучин монгол хэлнээс одоогийн монгол бичгийн хэлээр орчуулахдаа *Гуа-марал* (25-р тал), *Монголжсин гуа*, *Борогчин гуа*, *Алун-гуа* (26-р тал) гэв.

6. **Э.Хэйниш** энэ үгийг *hoai* хэмээн галиглаад түүнийгээ *WeiBlich* - *цайвар*, *grau* - *саарал* буюу *eine graue Hirschkuh* - *саарал марал* гэсэн үг хэмээн тайлбарлав. Харин *Алун гоо...* зэрэг үгний *гоо*-г *hoa* гэж галиглаад, дүрс бичигт *schön* (*von weiBer Hautfarbe*) ба (*сайхан цагаан арьстай*) гээд үүнийг эмэгтэй хүний нэртэй холбож хэлнэ гэж тайлбарлав. Зохиолыг герман хэлээр орчуулахдаа *Seine Gattin war eine weiBer Hirschkuh* буюу *Түүний гэргий нь цайвар зүстэй марал ажээ* гэв.

7. **Поль Пеллио** Нууц товчоон-ы эхийг латинчилахдаа *qo`ai-Maral*, *Alun-qo`a...* гээд улмаар францаар орчуулахдаа: *La Biche fauve* буюу *Улаан шарга Марал* гэжээ.

8. **Саган Сэцэний** Эрдэнийн товчид *qou-a maral* (32-р тал), *mongyuljin qou-a*, *boruǰin qou-a*, *Alun qou-a*, *Baruǰin qou-a* (34-р тал) хэмээн тус тус тэмдэглэв.

9. **Лувсанданзаны** Алтан товчид (4-р тал), *mongyuljin qou-a*, *boruǰin qou-a*, *Alun qou-a*, *baruǰin qou-a* (5, 6-р тал) хэмээн тус тус бичжээ. Хожим нь энэ зохиолыг Өвөрмонголын **Цоож** харьцуулж, тайлбарлахдаа: *qou-a* гэдгийг *you-a* (22, 23-р тал) хэмээвээс таарна гэсэн байна.

10. **П.Поуха** Нууц товчоог чех хэлээр орчуулахдаа *Bila lan* (11-р тал), галиглахдаа *choaj Maral* гэсэн нь *Цагаан Марал* гэж буй ажээ. Бусад онцгойлон авч үзэж буй үгсийн тухайд бол *Krasnou Mongolki*, *Krasnou Alun...* буюу (*гоё*, *үзэсгэлэнтэй*) хэмээн орчуулжээ.

11. **Вей Квей Сун** Нууц товчоог англи хэлээр орчуулахдаа: *a whitish doe* (46-р тал), (*цагаавтар согоо*) гэжээ. Цааш нь *Mongolchin Goa* (47-р тал), *Alun Goa...* (мөн тал) гэжээ.

12. **Л.Лигети** Нууц товчоог галиглан буулгахдаа: *Qo`ai-maral*, *Mongyuljin-qo`a*, *Alan-qo`a...* гэжээ. Улмаар мажаар орчуулгадаа *szarvasuno-volf* буюу *тод улаан марал* гэснээс үзэхэд мажаар хүн бугын зүсийг *улаан* гэдгээс өөрөөр хэлбэл ойлгохгүй байх талтай гэж үзнэ. *Mongkoldzsin-Koa* (9-р тал), *Alan-Koa...*(10-р тал) хэмээн тус тус бичсэнээс үзэхэд *хоу*, *гоо* буюу *зүс*, *гоё сайхан* зэрэг үгс нь өөр өөр утгатай гэдгийг үзүүлжээ.

13. **Игорь де Рахевилц** Монголын Нууц Товчоог галиглахдаа *qo`ai-maral*, *tongqoljin-qo`a*, *alun-qo`a...* хэмээн тус тус бичсэн байна. Энд тайлбар дагалдуулаагүй байна.

14. **Н.П.Шастинагийн** орос хэлээр орчуулж, оршил, тайлбар, хавсралты нь бичсэн Лу. Алтан товчид *Гоа-Марал*(153-р тал), *Монголжсин-гоа*, *Алун-гоа...*(154-р тал) гээд латин галигаар *you-a* гэж бичээд, түүнийгээ *Прекрасная-гоё*, *сайхан* гэсэн утгатай гэж тайлбарлажээ.

15. **Баяр** Нууц товчооны тэргүүн дэвтэртээ *qo`ai maral* гэж галиглаад, уйгаржин монголоор *qoway*, монгол бичгээр *qow-a maral* буюу *ухаа* (11-р тал) гэв. Харин *tongyulzin you-a* (3-р тал), *boruǰin you-a*, (4-р тал), *baruǰin you-a* (10-р тал), *Alun-you-a* (14-р тал) зэрэг үгсийн бичлэгийг *qou-a* нь уйгаржин монголынх, *you-a* нь монгол бичгийнх гэж тайлбарлав.

16. **Ино Уйе Ясеши** Бэртэ Чоно хэмээх зохиолдоо *you-a maral* гэсэн байна. Энд анхаарах нэг зүйл бол уг зохиол япон хэлээр бичигдэж, улмаар түүнийг Өвөр монголын Отгон хэмээх хүн орчуулсан байна. Орчуулагчаас тэмдэглэхдээ: - *Монголчуудын*

занишлд нийцээгүйг хасав гэснээс үзэхэд уг япон эхэд өөр хувилбар байсан байж болох, түүнийг олонд дасал болсон хувилбар *гоу-а* гэдгээр сольсон байж ч болох юм.

17. **Элдэнгтэй, Оюундалай** нарын Нууц товчооны харгуулан хянасан дэвтэрт *юи-а марал* (1-р тал), *боруҗин юи-а*, *Алун юи-а*(3-р тал) гэв. Энд ямар нэг тайлбар хийгээгүй байна.

18. **П.Кахны** хялбаржуулан бичсэн Монголын нууц товчоон буюу Чингис хааны гарал үүсэл хэмээх номондоо *a fallow beer* (3-р тал) гэж орчуулсан нь (*цагаан толбот шаргалдуу марал*) гэсэн үг ажээ. *Монголжсин гуа*, *Алун гуа* ... гэдгийн *гуа-г the fair* буюу *цагаан царайт* (4-р тал) гэж орчуулсан байна.

19. **Элдэнгтэй, Ардажав** нар Монголын нууц товчооны сийрүүлэг, тайлбартаа *qoqay maral*(4-р тал), *Алун юи-а*, *боруҗин юи-а*(15-р тал) гээд *Хохай* гэдгийг тайлахдаа бичгийн хэлний *хоха-гэдгээс хоай* буюу *гоу-а* эсхүл *губай* үүссэн буюу. *Цайвар өнгө* (*буурал өнгө*) буюу. Цааш нь Лу. Алтан товчид *хоу-а*, Эрдэнийн товчид мөн *хоу-а* байдаг хэмээн тэмдэглэсэн байна.

20. **Т.Дашцэдэн** Нууц товчоог латинчилахдаа *Qo`ai maral*, *Mongoljin ko`a*, *Alan ko`a*... (10, 11-р тал) гэжээ.

21. **Мансан** Нууц товчоог шинээр орчуулж тайлбарлахдаа *qou-a maral* (3-р тал), *боруҗин юи-а* (мөн тал), *Алун юи-а* (4-р тал), гээд *qou-a* нь *зүс* юм гэв. Ц.Дамдинсүрэн *хоу-а марал* гэж *гуа марал* (24-р тал) гэсэн үг гэж тайлбарласныг ишлэжээ.

22. **Их Мянгатай Иринчин** Нууц товчоог уйгаржин монгол бичигт сэргээн сийрүүлсэн эхдээ *qoqay maral*(1-р тал), *tongyulzin qoq-a*, *Alan qoq-a*...(7-р тал) гэж бичээд *qoqay* гэдэг нь *qow-a* гэсэн адууны *зүс* юм. *Qoq-a* гэдгийг эр хүйст үгтэй, *qoqay* -г эм хүйст үгтэй хэрэглэдэг хэмээн тайлбарлажээ.

23. **М.Таувле** Нууц товчоог орчуулахдаа *fable Hirsckuh* буюу *хонгор халиун марал* гэжээ. Харин *Монголжсин хо`а*, *Алан хо`а* ... гээд ямар нэг тайлбар хийгээгүй байна.

24. **Ш.Гаадамба** Нууц товчоог сэргээн сийрүүлэхдээ *qubay maral*(7-р тал), *tongyulzin yoba* (мөн тал), *Алан yoba*(8-р тал) гээд *хубай* гэдэг нь *ухаа* хэмээсэн монгол үг бөгөөд *губай* (*гуа*) гэсэн үг биш юм. *Гобай* нь орчин цагийн монгол хэлний *гуалиг сайхан* хэмээх үгний эртний бичлэг ба *гоа-г* эр хүйст үгэнд, *гобай-г* эм хүйст үгтэй бичнэ (222, 223-р тал) гэжээ. Тэрээр Книга Монголии номын “*Над строкой Сокровенного сказания*” гэдэг өгүүлэлдээ: -...*Хува-Марал* гэдгийг тайлбарлахдаа (*рыжесоловая лань*) гэсэн нь (*улаавтар шарга марал*)(156-р тал) хэмээсэн үг ажээ.

25. **Б.Сумьябаатар** Нууц товчооны үгсийн галиг бүтээлдээ *yoqai maral*, монгол үсгээр  $\text{ᠶᠣᠴᠠᠢ ᠮᠠᠷᠠᠯ}$  *yoqay maral*(7-р тал) гэжээ. Тэрээр цааш нь *Mongolzin-yoqa* (9-р тал), *Алан-yoqa*(12-р тал) гэжээ.

26. **П.Дарваев** Нууц товчоог халимаг хэлэнд буулгахдаа *Коай-Марал*(7-р тал), *Монголжсин-Коа*(8-р тал), *Алан-Коа*(9-р тал)... хэмээн тус тус бичив.

27. **Г.Г.Чимитов** уг зохиолыг буриад хэлэнд буулгахдаа *Гуаа марал* (7-р тал), *Монголжсин гуаа*(8-р тал), *Алан гуаа*...(9-р тал) гэсэн байна.

28. **Сайшнял** Чингис хааны товчоон зохиолын дээд дэвтэрийн нэгдүгээр бүлэгт *Гуа-марал*, *Алан-гуа* ... (7, 8-р тал) гэж бичээд *Гуа марал* гэдэг үгийг тусгайлан тайлбарлахдаа *Буртэ Чоно* гэдэг нэрийн бичлэг бараг бүр нэгдэлтэй байна. Гэтэл *Гуа марал* гэснийг хэд хэдэн янзаар бичиж байна.Тэрээр Эрдэнийн товч зэрэгт *хоу-а марал*, Ц.Дамдинсүрэнгийн орчуулсан Нууц товчоонд *Гуа Марал*, гэж тус тус бичиж байна. Харин Өвөрмонголын дэд профессор Баяр *Хува марал*, И.Иринжин *хогай марал* гэж

бичсэнийг дурдаад өөрөө сүүлчийн хоёр судлаачтай санал нийлж буй хэдий ч олонд ижил дасал болсон бичлэг *Гуа*-г баримтлан бичсэнээ тэмдэглэжээ(34-р тал).

29. **Д.Цэрэнсодномын** Нууц товчооны орчуулга, тайлбар бүтээлдээ *qow-a maral*(35-р тал), *tonggulzing you-a, boruicing you-a, baruizing you-a, alang you-a*(35, 36-р тал) гээд *Хува* гэдэг үгийг хятад хадмалд *цайвар* гэж тэмдэглэжээ гээд уг тайлбартай холбож Киргизд эмэгтэй хүний өвөг *ак марал* буюу *цагаан буга* байдаг нь монголчуудын эхийн онгон болох *хува марал*-тай адилавартай зүйл гэжээ.

30. **Хү.Дүрэвээ** Нууц товчоог тод монгол үсгээр буулгахдаа *Гува марал, Борогчин гува, Алун гува ...* гээд академич Ц.Дамдинсүрэн *Гува марал* гэж *хуа буга* гэсэн үг *хуа марал* гэж *гува марал* хэмээн тайлбарласныг дурджээ.

31. **Марие, Доминик** нарын Нууц товчооны франц орчуулгад *Biche fauve* буюу *шаравтар зүстэй марал* гээд түрэг хэлэнд үүнийг *quba* гэх ба францаар бол *Jaumatre, faube* буюу монгол хэлэнд *quba* гэсэн үг бий гэжээ.

32. **Чой Гихо**, Монгол улсын эрдэмтэн **Б.Сумьяабаатар** нарын эрхлэн хэвлүүлсэн Монголын нууц товчооны Монгол үсгийн анхны галигт  $\text{ᠭᠤᠮᠠᠷᠠᠯ} \text{ᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠨ}$   $\text{ᠭᠤᠮᠠᠷᠠᠯ}$   $\text{ᠭᠤᠮᠠᠷᠠᠯ}$  хэмээн тус тус тэмдэглэсэн байна.

33. **Өргөнгөө Ононы** Монголын Нууц Товчооны орчуулга, тайлбарт *Qo'ai-maral, ...Mongqoljin-qo'a, ...Boroqchin-qo'a, ...Alan Qo'a* хэмээн тус тус тэмдэглэв.

34. **Н.Доржготов, З.Эрэндоо** нарын Монголын Нууц Товчооны англи орчуулгад *Quai-maral(Fallow doe), ...Monggoljin-qou-a, ...Borugchin-qou-a, ...Alan-qou-a* хэмээн тус тус орчуулав.

35. **Ш.Чоймаа** Монголын Нууц Товчооны эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийхдээ- Гэргий инү Хоо марал ажээ(1-р зүйл). ...Монголжин гоо, ...Борогчин гоо(3-р зүйл), ...Алан гоо(7-р зүйл)... хэмээн тус тус тэмдэглэсэнээс үзвэл *Гуа марал уу, хоа марал уу* гэсэн асуулт гарч ирнэ. Монголчууд аливаа амьтны нэрийн өмнө тодотгол үг хэрэглэхдээ тэрхүү амьтны зүс заасан үгийг голдуу сонгож хэрэглэдэг. Жишээлбэл, саарал чоно, шар үнэг, хүрэн баавгай, халиун буга, цагаан зээр, бор гөрөөс, бор халзан туулай гэхээс гадна мал дээр ч нэгэн адил хоа морь, хоагч ингэ, буурал шүдлэн, хүрэн тайлаг, алагч үнээ...гэх мэтээр нэрлэдэг билээ.

Нууц товчоонд гарах малын зүс заасан үгсээс заримыг дурдвал, ...бор агтас(3-р зүйл), орог шинхулай(24-р зүйл), эрмэг хулагчин(87-р зүйл), шарга агт(90-р зүйл), бөөр алаг үхэр(100-р зүйл), хар буур(64-р зүйл)...гэснээс үзэхэд малынхаа сайхан, гоо, тааруухан гэдэг талаас хэрэглэсэн үг байхгүй дан зүсийг заасан үгс байна. Өөрөөр хэлбэл монгол хүн мал, амьтан, шувуу...зэргийн өнгө зүсээр хүний сэтгэлд хэр нийцтэй эсэхээр нь ойлгож иржээ. Харин Монголчууд аливаа мал амьтны шинж чанарыг илтгэх үгийг (сайн муу; сайхан муухай; хурдан хашин, номхон дошгин...) тэдний нэрийн хамт төдийлөн хэрэглэдэггүй бололтой. Хэрэглэх тохиолдолд зүсийг заасан үгний өмнө тухайн үгийг хэрэглэдэг байна. Жишээлбэл, сайхан борлог морь, ганган хул, тарган хээр ... гэхийн зэрэгцээ хонгор шарга, халтар халиун, хул алаг, хоа алаг, улаан бор, ухаа хонгор...гэж үндсэн зүсийг заасан үгийг нарийсган тодотгосон үгийг өмнө нь бас хоршиж хэлдэг байна.

Харин бугын зүсийн хувьд авч үзвэл нэлээд сонирхолтой юм. Энэ талаар ардын аман зохиол, ялангуяа ардын уртын болон богинын дуунд илүү тодорхой тусгасан байна. Анчны өгүүлснээр буга өвлийн цагт *цагаан халиун*, хаварт *халтар халиун*, зуны улиралд *улаан шаргал(ухаа буюу хоа)* зүстэй байдаг аж. Халх ардын “*Баруун хана*” хэмээх уртын дуунд;

*Халтар халиун буга нэгэн хоёр догдлоход  
Харамгүй сэтгэлтэн нэгэн хоёр мяраана.*

*Загал(цагаан) халиун буга нь нэгэн хоёр догдлоход*

Зүйрлэшгүй сэтгэлтэн нэгэн хоёр мяраана... гэснээс үзэхэд монголчууд мал, амьтаны зүсийг ихэд анхаардаг болох нь илэрхий байна. Цаг улиралыг дагаж амьтан зүсээ хувиргаж байдгийг нарийн ажиглаж явдаг болох нь илт байна.

Харин зарим мал, амьтны зүсийг нутаг нутагт өөр өөрөөр хэлж, нэг л янзаар бичиж ойлгож явдаг, энэ нь монгол хэл олон аялгуу, салбар аялгуутай болохыг гэрчлэн харуулж буй хэрэг юм. Жишээлбэл, халх аялгуутан адуу, үхэр, тэмээний цайвардуу улаан шаргал зүсийг ухаа хэмээн хэлж байхад, ойрад аялгуутан түүнийг хоа хэмээн хэлнэ. Энэ зүсийг монгол үсгээрээ бичихдээ нэг л янзаар *ᠬᠣᠠ* – qowa хэмээн бичээд халх нь ухаа – uqa, ойрад нь хоа-qowa хэмээн уншина. Энэ талаар монгол хэл шинжлэлийн тулгар бичгээс иш татвал, “Монгол бичгийн хэлний хува “светло-жёлтый, соломенно-жёлтый, бледный”, хуучин монгол бичгийн хэлнээ хуба-хаї, баруун халх аялгуунд хувахее, халх аялгуунд хуwa, баяд аман аялгуунд хō баруун халх аман аялгуунд хō – хуwa, мажар хэлэнд quwa “светло-жёлтый”, түрэг төрлийн хэлнүүд: тэлэнгэд аялгуунд куба “бледный”, Алтайн хэлэнд кубаһаї “бледный, светлый”, Якут хэлэнд кубархаї “бледный”; монгол бичгээр quwa-ᠬᠣᠠ хэмээн бичнэ”(Б.Я.Владимирцов 210-р тал).

Баруун монголын баяд, дөрвөдүүд одоо ч гэсэн адуу, үхэр, тэмээ, буга...зэрэг мал, амьтны цайвардуу, хул шарга зүсийг ухаа гэлгүй хоа хэмээн хэлдэг. Монгол бичгийн хэлэнд энэ хоёр үгийг qow-a гэсэн ганц дүрсээр тэмдэглэн бичээд, нутаг нутгийн аялгуунаа -o, -y хоёр авиаг бие биеэр нь сэлгүүлэн (хоа, хуа) дуудахад зориулагджээ. Түүгээр ч үл барам энэхүү хоа-хуа төв халхын аялгуунд qow-a - *ᠬᠣᠠ* гэж бичих боловч ярианд ухаа гэдэг нь монгол бичгийн хэлний бас нэг онцлог юм. Энэ талаар аливаа нэг хэлний бичгийн болон ярианы хэлний үг хоорондоо яв цав тохирч байх албагүйг гэрчлэж байгаа хэрэг юм.

Монгол ардын зарим дуунд гардаг адуу малын зүсийг заасан үгийг тусгайлан авч үзвэл, баруун монгол ардын “Хоа галзан морин” уртын дуунд;

*Хоа галзан морийгаа л,*

*Холын аянд унана аа л.*

*Хол нутгийн ах нар нь л,*

*Амар болоод мэнд л гэнэ ээ л ...хэмээн дуулдаг аж.*

Өөр нэг “Хүрэнгэй адуу” дуунд;

*...Хоотой адуу нь*

*Хонхроор гарлаа*

*Хонгор тэр минь*

*Хойноос нь гарлаа... хэмээн дуулна.*

БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны монгол хэлт зарим нутаг усны, тухайлбал Шилийн голоор дуулдаг “Алаг морь” дуунд:

*...Хоо шаргаан унаад гарлаа л*

*Хоргой торгоор бэлэг барив л*

*Хоюулаа тэгээд уулзаад явлаа л*

*Хожим нь нийлээд хуримаа хийв л...*

Мөн нутгийн Ордос ардын “Өндөр хоогийн араар” дуунд:

*Өндөр хоогийн араар*

*Үерийн мөндөр шаагилаа*

Үеийн бага дүүгийнхээ  
Үгийг нь сонсоод мордох юмсан.

Мөн ордос ардын өөр нэг дуунд:

Хоа юу морь минь  
Хондлой дүүрэн хуар  
Хонгор юу нөхөр минь  
Хормой дүүрэн хуар...

Улмаар энэхүү *хоа(хуа)* гэдэг тэмдэг нэрээс үйл үг бас үүсгэж хэрэглэнэ. Жишээ нь, баруун монголчууд ноосыг нь авсан тэмээг үс нь ургасхийгээд цайвардуу болж ирэхэд - Манай хэдэн тэмээ сайхан *хоарч* байна, сайхан *хоарчээ*, сайхан *хоарах* нь хэмээн ихэд таашаалтай хэлдэг нь угтаа -тэмээ маань өнгө зүсээ засаж байна, тарга хүчээ авч байна, тэвээрч эхлэж байна гэсэн үг ажээ. Нууц товчоонд өгүүлдэгээр; ...Тэнгис далайг гэтэлж...гэж байгаа болохоор энэ Марал өвлийн цагт нь эцэж турсанаа нөхөн гүйцээд, дээр өгүүлсэнчилэн ...сайхан *хоарч* өнгө засаад...хол нутгийг зорьжээ гэсэн утгаар ойлгож болохыг үгүйсгэх аргагүй.

**Энэ үгийг монгол хэл шинжлэлийн үндсэн баримт бичигт хэрхин тайлсныг авч үзье.**

О.Ковалевскийн “Монгол-Орос-Франц толь”-д *ᠬᠣᠶ᠋ᠢ* – красивый-сайхан, прекрасный-гоё, прелестный-үзэсгэлэнт, восхитительный-дур булаамаар(II-1016-р тал), харин хоо гэдэг үгний тухайд бол монгол үсгээр *ᠬᠣᠶ᠋ᠢ* · *ᠬᠣᠶ᠋ᠢ* · *ᠬᠣᠶ᠋ᠢ* хятадаар *hoang*, төвэдээр *dp'ser*, оросоор светлокоурый, беловатожёлтый, францаар (*cheval*) *roux*(II-974-р тал) хэмээн тус тус тайлж бичжээ.

А.Мостартын “Ордос толь”-д *ᠵᠣᠨ*(=*γōn*) *joli*, *beau/ γō saixan*... монгол үсгээр *γoua-ᠬᠣᠶ᠋ᠢ* хэмээн бичнэ(301-р тал), харин малын зүсэмийг заасан *х᠔ jaune pble, fauve clair х᠔ tsōxor mori... cheval fauve clair aves de petites mouchetures blanches*; газар усны нэр буйг дурдаад монгол үсгээр *ᠬᠣᠶ᠋ᠢ* · *ᠬᠣᠶ᠋ᠢ* · *ᠬᠣᠶ᠋ᠢ* хэмээн тус тус бичнэ(347-р тал).

Б.Я.Владимирцовын “Монгол бичгийн хэл, халх аялгуу хоёрыг харьцуулсан хэлний зүй”-д тэмдэглэхдээ: - Монгол бичгийн хэлэнд *γowa*, халх аялгуунд *г᠔* “красивый-сайхан, гуа, статный-гуалиг биетэй”, дөрвөлжин үсгээр *γo-ho*(205-р тал); цааш нь монгол бичгийн хэлэнд *хиwa ᠬᠣᠶ᠋ᠢ* > Баруун халхад, баяд аман аялгуунд *х᠔* “светло-жёлтый-цэгээн шар, хулсан шаргал, соломенно-жёлтый, бледный-цонхигор”(379-р тал) хэмээн тус тус тэмдэглэсэн нь энэ хоёр үгний хэрэглээ, утга хоёрыг тодорхой гаргасан болно.

**С.Шагжийн** “Монгол үгний тайлбар толь” бичигт бидний мөншиж буй *ухаа* гэдэг үгийг *qowa* буюу *qou-a* гэсэн хоёр хувилбараар бичээд *qow-a ьker* гэсэн хоршоо үг авч *үхрийн ху-а* өнгөтэйг нь: *qou-a* гэдгийг *морины хулаас шаравтар* болоод *цагаавтарханыг* нь хэлнэ гэжээ(413-р тал). Тэрээр *γobay* гэдгийн тайлбарт *эхнэрийн гуаг* нь хэмээснээс үзэхэд үүнийг зөвхөн эм хүйсийг заасан үгтэй хоршиж хэрэглэдэг болох нь тодорхой байна. *γou-a* гэдгийг тайлахдаа *хүн зэргийн овор сайханыг* нь хэлнэ (492-р тал) гэжээ.

2. **Б.Ринчен** “Монгол бичгийн хэлний зүй” дэд дэвтэртэй *ᠬᠣᠶ᠋ᠢ* гэдгийг латинаар галиглавал *γou-a*, кириллээр галиглавал *γou-a* гэсэн зүйл болно. Нууц товчооны *γo`a* нь ойрад хэл аялгуунаа *γoo* болно. Энэ нь ойрад хэл аялгуунаа тэгш, сайхан, аятай шулуун гэсэн утгатай, тэгш суу гэвэл *γoo суу* гэж одоо ч хэлдэг ажуу(215-р тал). Харин *qow-a, qou-a* гэдэг үг нь дундат эртний гэрч баримтын зүйлийг анхаарваас, *ko`a* гэж байваас зохих. ...Ордос аялгуунаа одоо *ko`a* гэдэг нь хоо болж, ойрад бүх аман аялгуунаа мөн



...Гэвч заарин тэнгэр ирж нүдэнд минь зааж үзүүлсэн нь, ухаагчин үнээ ирж Жамухыг тойрон явж, Жамухыг ба гэр тэргий нь мөргөсөөр өрөөсөн эврээ хугалж солжир эвэртэй болоод <<эврий минь өг>> гэж Жамухын зүг мөөрч шорой сацлан байна. Бас нэг мухар ухаа үхрийг их гэрт тэргэнд хөллөжээ.(Монголын Нууц Товчооны монгол, шинэ үсэг бичгийн эх, Гуравдугаар бөлөгийн 121-р зүйл)

### Товч дүгнэлт

1. Нууц товчоог судалсан эрдэмтдийн нэг хэсэг нь *Маралын* тодотголыг хоа (бичлэгийн болон дуудлагын хэд хэдэн хувилбартайгаар) буюу мал, амьтаны зүс хэмээсэн утгаар, нөгөө нэг хэсэг нь гуа, гоо (мөн бичлэг, дуудлагын хэд хэдэн хувилбартайгаар) буюу гоё, сайхан гэсэн утгаар авч хэрэглэжээ.

2. Харин маралын тодотгол үгийг *Монголжин гоо*, *Баргуужин гоо*, *Борогчин гоо*, *Алун гоо* гэдгийн *гоо*-гаас өөр утгатай гэж академич Ц.Дамдинсүрэн, А.С.Козин, Н.П.Шастина нараас бусад судлаач эрдэмтэд үзсэн байна.

3. Тухайн өгүүлбэрийн зэрэгцсэн өгүүлэхүүн гишүүний нэг *Чино* гэдгийн тодотгол нь түүний өнгө зүсийг заасан утгатай *саарал* хэмээх үг байгаа болохоор, нөгөө нэг гишүүнийх нь тодотгол мөн л зүс заасан буюу *хоа* гэсэн үг байхаас өөрөөр *гуа* гэж байх аргагүй мэт санагдана.

4. Энэхүү *хоа* гэдэг мал, амьтны зүсийг заасан үг одоо ч гэсэн ойрад аман аялгуунд энэ утгаар өргөн хэрэглэгдэж буйг харгалзан үзэх нь зохистой болов уу.

5. Нууц товчооны эх хятад ханзаас *марал* гэдэг үгний тодотголыг латин галигт буулгавал *sang bai* кириллээр буулгавал *цанг бай* болж, улмаар энэ нь *цайвар* гэсэн утгатай үг аж. Уг эхэд *Маралын* тодотгол үгийг *qo`ai*, *Монголжин*... зэрэгт хамаарахыг нь *qo`a* гэж өөр өөр дүрсээр тэмдэглэснийг ч мөн энд харгалзан үзэх ёстой болов уу.

6. *Маралын* тодотгол үг *qo`a* - *хоа* гэж байж болохыг бидний харьцуулан үзсэн хэл шинжлэлийн ном зохиол, лавлах хэрэглэгдэхүүн давхар нотлож байгаа юм.

### НОМ ЗҮЙ

Цэнд (1917), *Монголын нууц товчооны орчуулга*, Гар бичмэл.

Шагжа (1937), *Монгуул үсэг-үн дүрим-үн толи бичиг*, Улаганбагатур.

Позднеев А., *Транскрипция палеографического текста Юань чао ми ши*.

Козин А.С (1941), *Сокровенное сказание монголов*, Москва-Ленинград.

Shiratori Kurakichi (1942), *Onyaku Mobun gencho hishi*, Tokyo.

*Монгуул-ун нигуча тобчияан* (1947), Хагучин монгуул хэлэн-эчэ одо-ийн монгуул бичиг-үн хэлэ-бэр Чэндү-ийн Дамдинсүрэнг орчигулба, Улаганбагатур хота.

*Монголын Нууц Товчоо* (1957), Хоёрдахь удаагийн хэвлэл, Хуучин монгол хэлнээс одоогийн монгол хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав. Улаанбаатар.

Haenisch E (1948), *Die geheime Gescshichte der Mongolen Zweite verbesserte Auflage*, Leipzig.

Poucha P (1955), *Taina Kronika Mongolu*, Praha.

Wei Kwei Sun (1957), *The Secret History of the Mongol dynasty (Yuan-Chao-Pi-Shi)*, Aligarh.

Лувсандэндэв А (1957), *Монгол-Орос толь*, Улаанбаатар.

Саганг Сэчэн (1961), *Эрдэни-ийн товчи*, Улаганбагатур.



- Ligeti L (1962), *A Mongolok Titkos Tьrtenete*, Budapest.
- Ринчин Б (1966), *Монгол Бичгийн хэлний зүй*, Дэд дэвтэр, Улаанбаатар.
- Цэвэл Я (1966), *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар.
- Лувсанданзан (1973), *Золотое сказание Перевод Шестиной Н.П*, Москва.
- Hainesch E (1973), *Manghol in NiucaTobca`an*, Leipzig.
- Монголын нууц товчоо* (1976), III удаагийн хэвлэл, хуучин монгол хэлнээс одоогийн монгол хэлэнд Ц.Дамдинсүрэн орчуулав, Улаанбаатар.
- Гаадамба Ш (1976), *Нууц товчооны нууцаас*, Улаанбаатар.
- Байар (1981), *Монггул-ун нигуча товчийан*, тэригүн дэвтэр, Көкэхота.
- Ино Уйе (1981), *Бөртэ Чину-а*, Бэгэжинг.
- Дамдинсүрэн Ц, Лувсандэндэв А (1982), *Орос -Монгол толь*, Улаанбаатар.
- Базилхан Б (1984), *Монгол-Казах толь*, 1984.
- Лубсангданзан (1984), *Алтан тобчи*, Көкэхота.
- Дашцэдэн Т (1985), *Монголын нууц товчоо*, Улаанбаатар.
- Иринжин Й (1987), *Монггул-ун нигуча тобчийан*, Көкэхота.
- Сэцэнцогту (1988), *Монггул үсүг-үн ижагур-ун толи*, Өвүр монггул-ун арад-ун хэлбэл-ийн хорий-а.
- Table M (1989), *Monggul-un niuca tobca-an*, Leipzig.
- Дарваев П.А (1990), *Сокровенное сказание монголов Монгол-ун нигуча тобчийан*, Элиста
- Чимитов Г.Г (1990), *Сокровенное сказание монголов Монгол-ун нигуча тобчийан*, Элиста
- Sayisiyal (1991), *Chinggis khagan-u tovchiyan*, Terigun debter, kukeqota.
- Сумъяабаатар Б (1990), *Монголын нууц товчооны галиг*, Улаанбаатар.
- Marie-Dominique (1994), *History secrete des Mongols (Mongghol-un ni`uca tobciyan)*, Gallimard.
- Лүнтү (1994), *Ойирад нутуг-ун ауалгун-у үгэс-үн хурийангуй*, Өвүр монггул-ун йеке сургагули-ийн кэблэл-ийн хорий-а.
- Шагжа (1994), *Монггул Үгэн-ү Тайуалбури толи*, Бэгэжинг.
- Мансанг (1995), *Шинэ-бэр орчигулжу тайилбурилагсан Монггол-ун нигуча тобчийан*, Көкэхота.
- Чой Гихо, Сумъяабаатар Б (2005), *Монголын нууц товчооны Монгол үсгийн анхны галиг*.
- Igor de Rachewiltz (1972), *Index To The Secret History of the Mongols*, Indiana University, Bloomington.
- Норжин Ц, Манг.Мөрөн (1999), *Монггул хэлэн-ү толи*, Өвүрмонггул-ун арад-ун хэлбэл-үн хориу-а.
- Чоймаа Ш... нар (2007), *Монгол хэлний хэлзүйн толь бичиг I,II*, Улаанбаатар.
- Antoine Mostaert (1968), *Dictionnaire Ordos*, New York. London.
- Ковалевский О (1844), *Монгольско-руско-французский словарь*, Казань.
- Владимирцов Б.Я (1929), *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*, введение и фонетика, Ленинград.
- Urgenge Onon (2001), *The secret history of Chinggis khan*, The life and times of Chinggis khan Translated, annotated, and with an introduction by Urgunge Onon, London and New York.
- The Secret History of the Mongols Translated from Mongolian into English by N.Dorjgotov, Z.Erendo (2006), Ulaanbaatar.

Ш.Чоймаа (2006), *Монголын Нууц Товчооны эхийн шинэ хөрвүүлэг, буулгавар, тайлбар*, Улаанбаатар.

Э.Равдан (2008), *Монгол орны газар нутгийн нэрзүй*, Улаанбаатар.

Монгол ардын дуу (2003), *Эмхэтгэсэн Т.Гун-Аажав*, Улаанбаатар.

## РЕЗЮМЕ

В настоящей статье автор рассматривает переводы, интерпретацию слова <<Гуа>> из Сокровенного сказания монголов. Это слово употребляется в сочетании с существительным Марал-одним из тотемных имён §1 этого знаменитого памятника. Почему, именно это слово больше всего привлекает внимание автора? Потому что, оно по-разному понималось, переводилось и интерпретировалось исследователями Сокровенного сказания монголов. Здесь автор не даёт собственное объяснение слова, а он старается установить то, чей перевод и интерпретация являются точными и правильными или более близкими к оригиналу. Для этого в статье приводятся в качестве примера многочисленные переводы, интерпретации транслитерации исследователей этого замечательного памятника.

По мнению автора, А.С.Козин, Ц.Дамдинсурен, Н.П.Шастина, Г.Г.Чимитов, П.Дарбаев и другие считают, что это слово должно иметь значение Прекрасный, очень красивый, красавица, то есть у них *Гуа* в сочетании с существительным *Марал* и другое *Гуа* с существительными, обозначающими женский пол, *Монголжин*, *Борогчин*, *Баргужин*, *Алун* и другие имеет одно и то же значение: *красивая, прекрасная, красавица*, хотя у этих двух слов совсем неодинаковая транслитерация в оригинале.

Э.Хэниш, П.Пеллио, П.Поуха, Л.Лигети и другие исследователи учитывают разную транслитерацию этого слова при переводах, толкованиях и транскрипциях, то есть они перевели первое *Хо`ай* - прилагательным со значением масти животных, а второе *Хо`а* - качественным прилагательным. Между прочим, автор признаёт, что их переводы и толкования этих слов являются более близкими к оригиналу.

На наш взгляд, переводы и толкования данного слова, сделанные исследователями Ш.Гаадамба, Д.Церенсодном, Б.Сумъяабаатар, Баяр, Элдэнгтэй, Ардажав, Мансан, Иринжин и другими, являются точными и правильными потому, что у них первое слово *Хо`ай* обозначает масть животного, именно *каурая, рыжеватая, рыжесоловая*; другое слово *Хо`а* имеет значение *красивая, великолепная, прекрасная*.

В подтверждение своего мнения автор приводит многочисленные примеры, связанные с толкованием этого слова, из словарей монгольского, русского, английского, казахского и других языков, лингвистической литературы, местного говора и др.

Наконец, автор пришёл к такому выводу, что первое слово *Хо`ай* должно оно обозначать масть животного и переводиться словами *каурая* или *рыжесоловая*, а второе слово *Хо`а* - красоту женщины и передаваться словами *прекрасная, великолепная или красавица*.